



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс
санхүүжүүлсэн зардын гүйцэтгэл



**Аймгийн Сонгуулийн хороо нь анхан шатны
баримтын бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллаагүй,
зөрчлийг давтан гаргасан байна.**

2017 он

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр 2017 оны 07 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151, 7054-3156, 7054- 3179 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 208 тоот	Товчилсон үгийн тайлбар4 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5 БҮЛЭГ 1. Батлагдсан төсвийг журмын дагуу хуваарилан зарцуулсан боловч анхан шатны баримтын бүрдэлт дутуу байна. 1.1 СЕХ нь МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн төсвийг төлөвлөж батлуулсан байна. 1.2 Аймаг, сумдын сонгуулийн хороодод улсын төсвөөс нийт 69,006.2 мянган төгрөг хуваарилагдсан байна. 1.3 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан боловч АШБ-ын бүрдэлт дутуу байна БҮЛЭГ 2:Аймгийн Сонгуулийн хорооноос сонгуулийн зардлыг холбогдох журмын дагуу бүртгэж тайлагнасан боловч анхан шатны баримтын бүрдэлд хяналт тавьж ажиллаагүй байна. 2.1. Сонгуулийн зардлын бүртгэл хөтлөлт, гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнасан байна. 2.2. АШБ-ын бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан байна. Дүгнэлт Зөвлөмж Зөрчлийн нэгтгэл
---	---

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөө, ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилго, зорилт

МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс аймгийн Сонгуулийн хороонд олгосон хөрөнгийн зарцуулалтад Нийцлийн аудит хийж, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

3. Аудитын хамрах хүрээ

Аудитыг МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн зардалд олгохоор батлагдсан төсөв, гүйцэтгэл, Сонгуулийн хороодын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, мэдээ холбогдох бусад баримт материалуудыг хамрууллаа.

4. Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ аудитыг АДБОУС 100, АДБОУС 400, 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журам, холбогдох бусад журмуудыг ашиглахаас гадна шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, харьцуулах, дүн шинжилгээ, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, аудитын арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5. Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, чанарын хяналтыг хэрэгжүүлэн, аудитын менежер Г.Наранбаяр гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, хавсралт гэсэн агуулгаар үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Үндсэн мэдээлэл:

МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах аймгийн сонгуулийн хорооны үйл ажиллагааны зардлын санхүүжилтэд МУ-ын

2017 оны Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2, СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос 52,520.2 мянган төгрөгийн төсөв хуваарилсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтаар 3 нэр дэвшигчээс 50%+1 болзлыг хангаж чадаагүйгээс Ерөнхийлөгчийн сонгуульд хоёр дахь санал хураалт явуулах тухай Сонгуулийн тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.1, 105.2 дахь заалтуудын дагуу СЕХ-ноос 2 дахь шатны сонгуулийн зардалд 16,486.0 мянган төгрөг нэмэлтээр хуваарилагдаж, нийт 69,006.2 мянган төгрөг хуваарилагдан зарцуулагдсан байна.

Говьсүмбэр аймагт аймгийн сонгуулийн хороо-1, сумын сонгуулийн хороо-3, санал авах байр-9 байгуулагдан, тэдгээрт төрийн жинхэнэ болон үйлчилгээний 87 албан хаагч, мэдээллийн технологийн багийн ажилтан 15, нийт 102 албан хаагч ажилласан бол аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал авах байрны дэргэд итгэмжлэгдсэн 12 албан хаагч ажилласан байна.

Эхний шатны сонгуульд тус аймгаас саналаа өгөх 10,598 сонгогч нэрийн жагсаалтанд бичигдсэнээс 7,080 сонгогч саналаа өгч ирц 66.8 хувьтай байсан бол 2 дахь шатны сонгуульд 10,415 сонгогч нэрийн жагсаалтанд бичигдсэнээс 6,567 сонгогч саналаа өгч ирц 63.0 хувьтай гарсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан “Техникийн тооллого хийх журам”-ын дагуу санал хураалт дууссаны дараа намуудын ажиглагч нарыг оролцуулан, тэднээс томилсон этгээдээр сугалааг сугалуулж, техникийн тооллогыг эхлэхээс өмнө сонгогдсон санал авах байрны ахлах зохион байгуулагч, зохион байгуулагчид Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.6-д заасны дагуу санал хураалтын үр дүнгийн мэдээллийг СЕХ-д дамжуулсны дараа эхлүүлсэн бөгөөд завсарлагагүйгээр ил тод, нээлттэй зохион байгуулж, нийт 9 санал авах байрнаас 5 санал авах байрыг техникийн тооллогод хамруулсан бөгөөд тооллогын явцад зөрчил, маргаан гараагүй байна.

Аймгийн сонгуулийн хороонд нийт 5 өргөдөл, 2 хүсэлт ирснийг тухай бүрд нь шийдвэрлэж ажилласан байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд МАН, АН, МАХН-уудаас 19 ухуулах байранд нийт 207 хүн ажилласан бөгөөд менежер 3, шадар туслагч 57, ухуулагч 147 байна.

Аймгийн Сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтад аймгийн Сонгуулийн 1 дүгээр гарын үсгийг Сонгуулийн хорооны дарга Д.Тамир, 2 дугаар гарын үсгийг аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Н.Алтанцэцэг нар зурж, төсвийг захиран зарцуулсан байна.

Аймгийн Сонгуулийн хорооны даргыг Сонгуулийн ерөнхий хорооны 2017 оны 10 дугаар тогтоолоор, нягтлан бодогчийг аймгийн Сонгуулийн хорооны даргын 2017 оны 01 дүгээр захирамжаар тус тус томилсон байна.

Бүлэг 1

Батлагдсан төсвийг журмын дагуу хуваарилан
зарцуулсан боловч анхан шатны баримтын бүрдэлт
дутуу байна.

1.1. СЕХ нь МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн төсвийг төлөвлөж батлуулсан байна.

МУ-ын Сонгуулийн ерөнхий хороо нь МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн төсвийг төлөвлөн 2017 оны Төсвийн тухай хуулиар батлуулсан байна.

1.2. Аймаг, сумдын сонгуулийн хороодод улсын төсвөөс нийт 69,006.2 мянган төгрөг хуваарилагдсан байна.

Аймгийн Сонгуулийн хороонд 52,520.2 мянган төгрөгийн төсөв хуваарилагдсан бөгөөд МУ-ын Сонгуулийн ерөнхий хорооноос 2017 оны 113, 172, 199, 210 дугаар албан бичгүүдээр аймгийн Сонгуулийн хороонд хуваарилсан төсвийн зардлын тайлбар, төсвийн хуваарийг тус тус хүргүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтаар 3 нэр дэвшигчээс 50%+1 болзлыг хангаж чадаагүйгээс Ерөнхийлөгчийн сонгуульд хоёр дахь санал хураалт явуулах тухай Сонгуулийн тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.1-д “Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэн нь ч анхан шатны сонгуулийн нэгдсэн дүнгээр олонхийн санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр хүнийг хоёр дахь санал хураалтад оруулна”, 105.2-т “Сонгуулийн төв байгууллага хоёр дахь санал хураалтыг анхны санал авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор зарлан, зохион байгуулна” гэсэн заалтыг үндэслэн 2 дахь шатны сонгуулийн зардалд 16,486.0 мянган төгрөг хуваарилагдаж, СЕХ-ны 2017 оны 295 дугаартай албан бичгээр төсвийн хуваарийг төсвийн тайлбарын хамт ирүүлсэн байна.

СЕХ-ны 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 113 дугаар албан бичгээр сонгуулийн зардлын төсвийн хуваарь, төсвийн тайлбар, сонгуулийн хороодын дансны дугаарыг хавсралтаар ирүүлсэн байна. Төсвийн хуваарийн тайлбарт тухайн төсвийг зарцуулах лимит, тооцооллыг тодорхой тусгасан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн төсвийн хуваарийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	2 дахь шатны санал хураалтын нэмэлт төсөв	Нийт төсөв
1	Сургалтын зардал	2 110,0	-	2 110,0
2	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	250,0		250,0
3	Бичиг хэргийн зардал	3 020,0	295,0	3 315,0


4	Шуудан холбоо	2 870,0	340,0	3 210,0
5	Унааны зардал	4 900,0	775,0	5 675,0
6	Сурталчилгааны зардал	3 000,0		3 000,0
7	Сурталчилгааны материал хүргэх зардал	375,0		375,0
8	Санал авах байр бэлтгэх зардал	1 800,0		1 800,0
9	Саналын хуудас хүргэх	1 169,0	1 169,0	2 338,0
10	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	1 800,0	894,0	2 694,0
11	Мэдээ дамжуулах зардал	435,0	435,0	870,0
12	Томилолтын зардал	1 180,0		1 180,0
13	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	378,0	378,0	756,0
14	Болзошгүй зардал	1 000,0		1 000,0
15	Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардал	24 124,4	8840,0	34524,4
16	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	4 108,8	1 800,0	5908,8
НИЙТ		52 520,2	16 486,0	69 006,2

Хүснэгтээс харахад: 2 дахь шатны санал хураалтын зардал нийт төсвийн 23.9 хувийг эзэлж байгаа бөгөөд нэн шаардлагатай урсгал зардлуудыг нэмж олгосон байна.

Аймгийн Сонгуулийн хорооноос МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн зардлын санхүүжилтийг сумдын сонгуулийн хороонд хуваарилсан байна.

Сонгуулийн зардлын санхүүжилтийг аймаг, сумдад хуваарилсан байдлыг графикаар харуулбал:

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ /Сонгуулийн хороодоор/



Графикаас харахад: Нийт зардлын 53 хувийг аймгийн Сонгуулийн хорооны зардал эзэлж байгаа нь мэдээллийн технологийн багийн ажилтнуудын урамшуулал, хоолны зардал, сургалтын зардал хуваарилагдаж ирсэнтэй холбоотой байна.

1.3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан боловч АШБ-ын бүрдэлт дутуубайна.

Тус аймагт МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн зардалд СЕХ-ноос нийт 69,006.2 мянган төгрөгийн санхүүжилтхуваарилагдсаныг бүрэн зарцуулсан байна.

Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Нийт Төсөв	Гүйцэтгэл /Сонгуулийн хороодоор/			
			Аймаг	Сүмбэр сум	Шивээговь сум	Баянтал сум
1	Сургалтын зардал	2 110,0	2 110,0			
2	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	250,0	250,0			
3	Бичиг хэргийн зардал	3 315,0	720,0	1 390,0	610,0	595,0
4	Шуудан холбоо	3 210,0	1 080,0	1 370,0	570,0	190,0
5	Унааны зардал	5 675,0	1 450,0	2 625,0	975,0	625,0
6	Сурталчилгааны зардал	3 000,0	3 000,0			
7	Сурталчилгааны материал хүргэх зардал	375,0		225,0	75,0	75,0
8	Санал авах байр бэлтгэх зардал	1 800,0		1 200,0	400,0	200,0
9	Саналын хуудас хүргэх	2 338,0	2 338,0			
10	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	2 694,0	2 694,0			
11	Мэдээ дамжуулах зардал	870,0	870,0			
12	Томилолтын зардал	1 180,0	1 180,0			
13	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	756,0	756,0			
14	Болзошгүй зардал	1 000,0	848,0	152,0		
15	Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардал	26 124,4	4 709,2	11 650,0	5 809,2	3 956,0
16	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	14 308,8	14 308,8			
НИЙТ		69 006,2	36 314,0	18 612,0	8 439,2	5 641,0

Хүснэгтээс харахад: Нийт зардлын 52.6 хувь буюу 36,314.0 мянган төгрөгийг аймгийн Сонгуулийн хороо, 26.9 хувийн буюу 18,612.0 мянган төгрөгийг Сүмбэр сумын Сонгуулийн хороо, 12.2 хувь буюу 8,439.2 мянган төгрөгийг Шивээговь сумын Сонгуулийн хороо, 8.2 хувь буюу 5,641.0 мянган төгрөгийг Баянтал сумын Сонгуулийн хороотус тус зарцуулсан байна.

Аудитын явцад дараах зөрчил дутагдлууд илэрлээ. Үүнд:

- ✓ Сүмбэр сумын сонгуулийн хорооноос МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн 2 дахь шатны санал хураалтын үед аймгийн Сонгуулийн хороонд алслагдсан байрлалтай 3 санал савах байранд

шатахууны зардалд нийт 150.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэх тухай албан бичиг ирүүлсний дагуу болзошгүй зардлын санхүүжилтээс 152.0 мянган төгрөгийн шатахууны талоныг хүргүүлсэн боловч 150.0 мянган төгрөгөөр тайлагнасан бөгөөд нийт 4.6 мянган төгрөгийн шатахууныг анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан байна.

- ✓ СЕХ-ны 2017 оны 19 дүгээр тогтоолоор МУ-ын Ерөнхийлөгчийн 2013 оны ээлжит сонгуулийн саналын хуудсыг устгах зөвшөөрөл олгосныдагуу аймгийн ИТХТ-ийн 2017 оны 18 дугаар тогтоолоор саналын хуудсыг устгах ажлын хэсгийг байгуулагдаж, уг ажлын хэсэг саналын хуудсыг устган тайланг СЕХ-нд хүргүүлсэн байна. Дээрх чиглэлийн дагуу аймгийн Сонгуулийн хороо МУ-ын Ерөнхийлөгчийн 2013 оны ээлжит сонгуулийн саналын хуудсыг устгах зардлыг тооцохдоо 780.0 мянган төгрөгийн ажлын хөлс, 68.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулахаар, нийт 848.0 мянган төгрөгийг болзошгүй зардлаас зарцуулсан байна. Гэвч уг зардлаас 78.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогод шилжүүлсэн бөгөөд 770.0 мянган төгрөгийг төсвийн зарцуулалтад хяналт тавих эрх бүхий нягтлан бодогч нь өөрийн хувийн харилцах дансанд шилжүүлсэн, ажлын хөлс болон шатахууны зардлыг хэнд, хэдэн төгрөг олгосон нь тодорхойгүй, ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан байна.
- ✓ Аймгийн Сонгуулийн хорооны нягтлан бодогч нь сумдын сонгуулийн зардлын тайланг нэгтгэхдээ анхан шатны баримтын бүрдлийг хянаж хүлээн аваагүй байна.
- ✓ Аймгийн Сонгуулийн хорооны нягтлан бодогч нь өмнөх сонгуулиудад нягтлан бодогчоор удаа дараа ажилласан бөгөөд анхан шатны баримтын бүрдүүлэлт, сумдын сонгуулийн хороодын зардалд хяналт тавьж ажиллаагүйгээс өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан байна.

Эдгээр нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6-д “Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нягтлан бодогч сум, дүүргийн сонгуулийн хорооноос ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтыг шалган, акт үйлдэн хүлээн авч, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны санхүүгийн анхан шатны баримтын хамт архивын нэгж болгон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын архивт албан ёсоор хүлээлгэн өгнө” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд төсвийн хөрөнгийг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр зарцуулж, ажил гүйлгээг данс бүртгэлд тусгасан нийт 774.6 мянган төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт бичив.

Бүлэг 2

Аймгийн Сонгуулийн хорооноос сонгуулийн зардлыг
холбогдох журмын дагуу бүртгэж тайлагнасан боловч
анхан шатны баримтын бүрдэлд хяналт тавьж
ажиллаагүй байна.

2.1 Сонгуулийн зардлын бүртгэл хөтлөлт, гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнасан байна.

Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороо, санал авах байруудад СЕХ-ноос ирүүлсэн чиглэлийн дагуу холбогдох мэдээллийг цаг тухайд нь хүргэж, мэргэжил, арга зүйн удирлагаар хангаж ажилласан байна.

СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”, СЕХ-ноос тухай бүр ирүүлсэн чиглэлийн дагуу МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар нь бүртгэж тайлагнасан байна.

2.2 АШБ-ын бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Аймгийн хэмжээнд МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн зардлаасбичиг хэрэг, санал авах байр тохижуулах материал, шатахуун, эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардалд нийт 17,624.5 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансаар дамжуулан шаардах хуудсаар зарцуулсан бөгөөд ашиглагдаагүй үлдсэн хөрөнгө байхгүй байна.

Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-ноос ирүүлсэн чиглэлийн дагуу сумдад санхүүжилтийг хуваарилсан боловч, сумдаас зардлын гүйцэтгэлийн тайланг гаргуулан, хүлээн авч нэгтгэхдээ анхан шатны баримтын бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллаагүй, АШБ-гүй ажил гүйлгээг гүйцэтгэж, зөрчлийг давтан гаргасан байна.

Аудитаар нийт 774.6 мянган төгрөгийн зөрчил илэрснийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт бичиж, 1 зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Аймгийн Сонгуулийн хороо нь СЕХ-ноос ирүүлсэн санхүүжилтийг холбогдох журмын дагуу зардлын зүйл ангиар нь сумдад хуваарилан зарцуулсан байна.
2. Сонгуулийн зардлын гүйцэтгэлд бүртгэлээр тавих хяналт сул, сумдын зардлын тайланг хянаж хүлээн аваагүй, анхан шатны баримтын бүрдэлд хяналт тавьж ажиллаагүй, АШБ-гүй ажил гүйлгээг хийж гүйцэтгэсэн, зөрчлийг давтан гаргасан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Сонгуулийн хорооны дарга Д.Тамирт:

1. Төрийн аудитын байгууллагаас тогтоосон актыг хугацаанд нь бүрэн барагдуулах